

## ТӨГРӨГИЙН ДУУ: ЗУУН ЖИЛИЙН ЗҮРХНИЙ ЦОХИЛТ

Төгрөгийн дуу бол зөвхөн мөнгөний тухай түүх биш. Энэ бол ардын итгэлийн зуун жилийн цохилт юм. Намрын шаргал навчис хөл дор хагдарч, үүлгүй тэнгэрийн доорх Улаанбаатарын гудамжинд нэгэн өндөр настан, халуун савтай цайгаа тулгуурлан, гурав нугалсан хэдэн дэвсгэртийг дэлгэн тоолж сууна. Гар нь чичирнэ. Гэвч харц нь тунгалаг, тэр дэвсгэртүүд рүү биш ирээдүй рүү ширтэж буй мэт. Тэрбээр дэвсгэртийнхээ завсраас нэгэн мөнгөн тэмдэгтийг удаан гэгч нь эгцлэн харснаа, “За даа... чи минь ч надаас илүүг үзэж туулсан даа” хэмээн шивнэв. Энэ бол монгол төгрөг. Энгийн мэт хэр нь эгэлгүй энэ зүйл бидний өнгөрсөн, өнөө, ирээдүйг нэгэн зүгт хөтлөх амьд гэрч, зуун жилийн үнэ цэнийн үргэлжлэл юм.

Энэ зуун жилийн хугацаанд төгрөг зөвхөн эдийн засгийн хэрэгсэл биш, нийгмийн сэтгэл зүй, соёлын илэрхийлэл болж хөгжсөөр ирсэн юм. Харин өнөөдөр бид төгрөгөө ямар нүдээр харж байна вэ? Бид төгрөгийн утга учир, үнэ цэнийг зүрх сэтгэлээрээ мэдэрч байна уу, эсвэл зөвхөн үнэ ханшаар хэмжиж, алдагдсан итгэлтэйгээр харьцаж байна уу? Үнэндээ төгрөг гэдэг бол бидний итгэл найдвар, үндэсний дархлаа, нийгмийн ухамсрын хэмжүүр юм. Түүнийг хэрхэн хайрлаж, хүндэтгэж, хэрэглэхээс шалтгаалж улс орны маань ирээдүйн оршихуй тодорхойлогдоно. Монгол төгрөг — энэ нэр монгол хүний сэтгэлд юу ч юм нэгийг хөнддөг. Төгрөг бол зөвхөн худалдаа арилжаанд хэрэглэгдэх хэрэгсэл бус, тусгаар тогтнолын бэлгэдэл, тус тустын түүхийг нэгтгэх зүрхний хэл, мартагдаж болохгүй үнэний дуу хоолой билээ. 1925 оны түүхэн өдөр Монгол Улс анх удаа өөрийн мөнгөн тэмдэгттэй болж, “төгрөг” хэмээх нэр монголчуудын зүрх сэтгэлд хоногшин үлджээ. Тэр үеэс өнөөдрийг хүртэл төгрөг бол монгол

хүний итгэлийн илэрхийлэл байсаар ирсэн. Төгрөг бол төрийн тусгаар тогтнолын баталгаа. Ардчилсан, бүрэн эрхт улсын туг лугаа адил, төгрөг нь тусгаар тогтносон улсын мөнхийн бэлгэдэл. Нэгэн зуун жилийн турш энэ нэр алдагдаагүй, үнэ цэн нь соригдсоор ирсэн ч хэзээ ч унаагүй.

Төгрөггүйгээр Монгол төр орших уу? Төргүйгээр төгрөг орших уу? Энэ хоёр бие биеэсээ салшгүй нэгдмэл нэгэн зүйл ажээ. Гэвч бид өнөөдөр төгрөгийнхөө үнэ цэнийг үнэхээр ойлгож байна уу? Бидний дунд төгрөгийг зөвхөн “үнэ ханш”-ийн хэмжүүр, ам долларын ханштай уралдуулж ярьдаг хандлага газар авсан. Хүмүүс төгрөгийг “чанаргүй”, “үнэгүй” хэмээн дорд үзэх нь улам олширсоор.

Гэвч төгрөгийн үнэ цэнэ унасан уу, эсвэл бидний итгэл нь суларсан уу? Төгрөгийн үнэ цэнэ бидний хандлагаар хэмжигддэг. Хэрвээ бид төгрөгт хүндэтгэлгүй хандвал, тэр ч бас биднийг орхино. Бид түүнийг хайхрамжгүй нугалж, сэглэж, халаасандаа чихэж, ахархан бодлоор дүгнэдэг. Гэвч тэр жижигхэн дэвсгэрт бүрийн ард нэгэн цагт тусгаар тогтнолын төлөө цусаа урсгасан өвөг дээдсийн маань сүнс, хөдөлмөр, итгэл шингэсэн гэдгийг мартаж болохгүй. Төгрөгийн үнэ цэнийг зөвхөн төр засгийн бодлого хадгалахгүй, иргэд бид өөрсдөө ч мөн хариуцлага үүрэх ёстой. Мөнгөний зөв хэрэглээ, зохистой хэрэглээний соёл нь төгрөгийн үнэлэмжийг хадгалах чухал хүчин зүйл болдог. Өрхийн санхүүгээ төлөвлөж, орлого зарлагаа зөв зохицуулах, илүүдэл мөнгөө хадгалах, ухаалгаар хөрөнгө оруулах, хэт зээлд автахгүй байх зэрэг нь санхүүгийн сахилга батыг төлөвшүүлж, нийгэмд тогтвортой орлого зарлагын харилцааг бий болгодог. Энэ нь эцэстээ үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн бодит үнэ цэнийг тэтгэж байдаг сэтгэлгээний соёл юм.

Харин бид төгрөгийг шинэ нүдээр харах цаг иржээ. Төгрөг бол зөвхөн өнгөрсөн үеийн дурсамж биш, ирээдүйн хөгжил дэвшлийн үндэс суурь. Хэрвээ бид төгрөгийн үнэ цэнийг хамгаалж чадвал, бидний тусгаар тогтнол мөнхөд баталгаажих болно. Төгрөгөө хайрлах гэдэг нь Монгол Улсаа хайрлаж буй хамгийн бодит үйлдэл юм. Монголчуудын сэтгэл зүрхэнд мөнгөний тухай ойлголт эртнээс өвөрмөц байсан. Монгол бичигт “төгрөг” гэдэг үг “дугуй”, “бүтэн” гэсэн утгатай. Энэ нь орчлонгийн эргэлт, оршихуйн төгөлдөр байдлыг илэрхийлдэг. Төгрөг гэдэг үг анхнаасаа л дуусашгүй эргэлт, бүтэн оршихуйн бэлгэдэл байжээ. Тиймээс төгрөг зөвхөн эдийн засгийн ойлголт бус, гүн ухааны утга агуулгатай, үндэсний сэтгэлгээний цөм мөн. Харин одоо, бид төгрөгийг зөвхөн хэрэглээний зүйл гэж харах биш, сэтгэл зүйн шинэ хандлага бүрдүүлэх шаардлагатай болжээ.

Төгрөгийн тухай ярихдаа бид өөрсдийн үнэт зүйлс, амьдралын хэв маяг, ирээдүйн зорилго, нийгмийн хандлага, боловсролын үнэлэмж гээд бүх л зүйлээ давхар тусган хардаг. Иймд төгрөгийн үнэ цэнийг хамгаална гэдэг нь зөвхөн инфляцтай тэмцэх бус, үндэстний ухамсрыг сэргээх, иргэний хариуцлагыг дээшлүүлэх, шинэ үеийн сэтгэлгээний өөрчлөлтийг эхлүүлэх түүхэн алхам билээ. Энэ бүхэн боловсролоос эхэлнэ. Санхүүгийн боловсрол нь зөвхөн мөнгө хадгалах, зарцуулалт хийх ур ухаан бус үндэсний мөнгөн тэмдэгтийн утга учрыг ойлгох, хүндэтгэх, хойч үедээ уламжлуулах эрхэм соёл юм. Хэрэв бид бага насны хүүхдүүдэд төгрөгийн тухай зөв ойлголтыг суулгаж чадвал, тэд зөвхөн эдийн засгийн ирээдүйг биш, сэтгэлгээний шинэ түүхээ болох ирээдүйг бүтээгчид байх болно. Монголбанкнаас санаачилсан “Төгрөг 100” аян бол зөвхөн ой тэмдэглэх зорилготой акц бус, үндэстний мөнгөн тэмдэгтээ сэргээн үнэлэх, шинэ үеийн ухаарал, сэтгэлгээний хувьсгал эхлүүлэх уриа юм. Энэ бол эх орноо хайрлахын

хамгийн тод илэрхийлэл. Хэрвээ бид төгрөгийн тухайд нэгэн дуугаар “бид хайртай” гэж хэлж чадвал, төгрөг ч бидний итгэл дээр бат зогсох болно. Гэхдээ төгрөгийг хамгаалах нь зөвхөн иргэдийн ухамсар дээр тогтохгүй. Энэ нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хариуцлагатай бодлого, тогтвортой эдийн засгийн орчны үр дүн байх учиртай. Төсвийн сахилга бат, үндэсний үйлдвэрлэлийн дэмжлэг, экспортыг нэмэгдүүлэх бодлого зэрэг олон хүчин зүйл нийлж байж төгрөгийн үнэ цэнийг баталгаажуулна.

Төгрөгийн ирээдүй бас технологийн давлагаатай салшгүй холбогдож байна. Цахим шилжилтийн эрин үед дижитал төгрөгийн ойлголт, блокчэйн технологийн ашиглалт, нээлттэй эдийн засгийн оролцоо зэрэг нь уламжлалт дэвсгэртийн үүргийг өөрчлөх шинэ орон зайг нээж буй. Харин бид энэ шинэчлэлийг зөвөөр удирдаж чадвал, төгрөг зөвхөн түүхэн биш, ирээдүйд чиглэсэн сэтгэлгээний мөнгөн тэмдэгт болох боломжтой.

Энэ бүхнээс хамгийн чухал нь — итгэл. Ард түмэн төгрөгт итгэж байж, төгрөг улс оронд итгэл даадаг хүчирхэг дэмжлэг болно. Төгрөгт итгэнэ гэдэг нь халаасандаа байгаа дэвсгэртэд биш, эх орныхоо ирээдүйд, өөрийнхөө чадварт, нийгмийн эв нэгдэлд итгэж байгаа хэрэг юм. Тиймээс бид төгрөгт итгэх нь Монголынхоо ирээдүйд итгэхтэй адил үйлдэл гэдгийг ойлгох ёстой. Төгрөгийн зуун жилийн замнал бидэнд зөвхөн өнгөрснийг хүндэтгэх бус, ирээдүйг ухаалаг төлөвлөх шаардлагыг сануулж байна. Үндэсний мөнгөн тэмдэгтээ хайрлах нь дэвсгэртийг нямбай хадгалах төдий зүйл биш энэ бол улс орноо хайрлах, эдийн засгийн дархлаагаа хамгаалах, ирээдүйгээ бат бөх суурьтайгаар бүтээх ухамсрын илэрхийлэл юм. “Төгрөг 100” бол бидний гар дээр үлдсэн дурсамж биш, харин дараагийн зууны амжилтад хүргэх итгэлийн үндэс билээ.

**Төгрөгийн** үнэ цэнэ бол зүгээр нэг ханшийн тоо биш. Энэ бол бидний эдийн засагт итгэх итгэл, улс орныхоо ирээдүйд тавьж буй үнэлэмжийн хэмжүүр юм. Хэрэв бид төгрөгөө хайрлахгүй бол гадаад валютын хамаарал улам гүнзгийрч, эдийн засгийн тусгаар тогтнол алдагдах эрсдэлтэй. Харин бид төгрөгтөө итгэж, үнэлж, хайрлаж чадвал тэр итгэлээр эдийн засгийн суурь бэхжиж, ирээдүй маань бат бөх болно. Эцэст нь асууя: та төгрөгийг хайрлаж чадаж байна уу? Та төгрөгийг нэгэн үеийн өвөг дээдсийн чинь сэтгэлийн дуудлага, тэмцлийн гэрч, ирээдүй хойч үеийн чинь итгэлийн тулгуур хэмээн харж чадаж байна уу? Төгрөг энэ бол бидний зүрхний цохилт. Тэр зуун жил тасралтгүй цохилсон. Бидний итгэл тасарвал тэр чимээгүй болно. Харин бид итгэлээ сэргээж, үнэ цэнээ ухаарч чадвал тэр бидний зүрхтэй хамт дахин зуун, дахин мянган жил цохилсоор байх болно.

**Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын**

**1 дүгээр Сургууль, 12г ангийн сурагч**

**Отгонбаатар овогтой Халиунаа**